



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/225

Булган

Захирал, эрхлэгч нарын ур чадварын  
нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай


Монгол улсын Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3, 40.4.2, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 2010 оны “Шалгуур үзүүлэлт батлах тухай” 362/112/183 дугаар хамтарсан тушаалын хавсралтын 6, 10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргаас төсвийн шууд захирагч нартай байгуулсан Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж буй байдал, үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг харгалзан Ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч нарын 2018 оны сүүлийн хагас жилийн ажлыг журамд заасан үзүүлэлтийн дагуу дүгнэсэн үнэлгээг харгалзан үзэж, ур чадварын нэмэгдэл олгох хувь хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Ур чадварын нэмэгдлийг 2019 оны 01 сарын 01-ээс 07 сарын 01-ний өдрийг хүртэл хавсралтад заагдсан хувь, хэмжээгээр байгууллагын тухайн жилийн цалингийн санд батлагдсан ур чадварын нэмэгдлийн санд багтаан сар бүр тооцон олгохыг Ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны А/574 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

Аймгийн Засаг даргын 2019 оны ... дугаар сарын ... ны өдрийн ... дугаар захирамжийн хавсралт

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ,  
СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХЛЭГЧ  
НАРТ ОЛГОХ УР ЧАДВАРЫН НЭМЭГДЛИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ**

Д/д	Сум, байгууллагын нэр	Ажлын хэсгийн үнэлгээ		Нэмэгдэл олгох хувь	
		Сургуулийн Захирал	Цэцэрлэгийн Эрхлэгч	Сургуулийн Захирал	Цэцэрлэгийн Эрхлэгч
1	Баян-Агт	92.0	83.0	25	20
2	Баяннуур	88.6	96.0	20	25
3	Бугат	90.0	88.0	25	20
4	Бүрэгхангай	90.0	90.0	25	25
5	Гурванбулаг	87.0	72.9	20	-
6	Дашинчилэн	80.0	89.0	15	20
7	Орхон	88.2	90.2	20	25
8	Могод	80.6	71.0	15	-
9	Сайхан	95.0	86.7	25	20
10	Сэлэнгэ	80.0	97.1	15	25
11	Рашаант	91.8	93.5	25	25
12	Тэшиг	86.1	90.8	20	25
13	Хангал	86.4	85.0	20	20
14	Хишиг-Өндөр	БСШУСЯ	88.6	БСШУСЯ	20
15	Хялганат	90.0	91.0	25 <i>/II-VII сар/</i>	25
16	Хутаг-Өндөр	96.7	95.4	25	25
17	Булган сум I сургууль	88.7	-	20	
18	Булган сум ЭӨЦС	БСШУСЯ	-	БСШУСЯ	
19	Булган сум Спортын сургууль	78.3	-	-	
20	Булган сум III сургууль	91.0	-	25	
21	Булган сум 1-р цэцэрлэг	-	91.1		25
22	Булган сум 2-р цэцэрлэг	-	95.6		25
23	Булган сум 3-р цэцэрлэг	-	93.8		25
24	Булган сум 4-р цэцэрлэг	-	90.2		25
25	Булган сум 6-р цэцэрлэг	-	90.8		25
26	Булган сум 7-р цэцэрлэг	-	94.6		25